**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

/2023 оны жилийн эцсийн байдлаар /

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА**

2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр.

| ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Эх үүсвэр | Суурь түвшин /суурь он - 2022 он/ | 2023 он | | Хэрэгжилтийн явц, үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв | |
| **ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **Хөдөлмөр нийгмийн хамгаалал** | | | | | | | |
| **2.5 Хүн амын хөгжлийг хангаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдэ ядуурлыг бууруулна.** | | | | | | | |
| 2.5.3 Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан дэд бүтцийг сайжруулж,шинээр баригдаж байгаа зам талбай, барилга байгууламжид саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ. | 3 | Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан дэд бүтцийг сайжруулж,шинээр баригдаж байгаа зам талбай, барилга байгууламжид саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ. | БТ | - | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ авах орчныг бүрдүүлэх | 243182,6 | Байгууллагын мэдээллийн бүх самбрыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд харахад хялбар байдлаар хийж байршуулсан.<br>Үр дүн: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ авах орчин нөхцөлийг байгууллагын түвшинд шийдвэрлэсэн.<br>Хэрэгжилт 100 хувь. |
| **Үндэсний бахархал, өв соёл** | | | | | | | |
| **2.6. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёл урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.** | | | | | | | |
| 2.6.7. Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчид болон төрийн байгууллагуудын албан хаагчдын Монгол хэл, бичгийн чадварыг | 9 | Төрийн байгууллагын албан хаагчдыг Монгол бичгийн сургалтад хамруулж, хуучин Монгол бичгээр унших, бичих чадавхыг сайжруулж, албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр явуулж эхэлнэ. | БТ | - | Зохион байгуулсан сургалтын тоо-5<br><br>Нийт төрийн албан хаагчдын 50 хувийг сургалтад хамруулна. | 243182.6 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс байгууллагадаа 2021 оноос эхлэн “Хүмүүн бичиг” сонин захиалж байсан боловч Төрийн хэмнэлтийн тухай хууль гарсантай холбоотой хэвлэл захиалгыг зогсоосон. Байгууллагын хаяг болон мэдээллийн самбарыг монгол бичгээр хийсэн. Монгол бичгийн анхан шатны мэдлэгтэй 2 албан хаагчийг албаны даргын үндэсний бичгийн анхан шатны мэдлэг олгох хувийн сургалтад хамруулж байгаа бөгөөд бусад дунд болон дундаас дээш мэдлэгтэй албан хаагчид цахим хэлбэрээр сургалтад хамрагдаж |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| дээшлүүлж, уламжлалт Монгол бичгийг албан хэргийн түвшинд ашиглаж эхэлнэ. | | | | | | | байна. Мөн албан хэрэг хөтлөлтийг монгол кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулахтай холбогдуулан төрийн байгууллагуудын холбогдох албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг дээшлүүлэх, цахим бичвэр боловсруулах арга аргачлалд сургах сургалтад хамрагдан албан хэрэг хөтлөлтийн mongpad программыг суулган албан хэрэг хөтлөлтдөө ашиглахаар хэвлэлтийн тохиргоог хийсэн. Дээрх арга хэмжээтэй холбоотой үндэсний бичгээр албан бланкийг хэвлүүлэн хүлээн авч хосолсон хэлбэрээр хөтлөх бэлтгэл 85 хувьтай хангагдаад байна.<br>Үр дүн: Ажилчид 100 хувь монгол бичгийн мэдлэгтэй болсон.<br>**Хэрэгжилт: 100%** |
| 2.6.8 Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууды н үйл ажиллагааг дэмжин, хамтран ажиллана. | 11 | Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр хамтран ажиллана. | БТ | - | Гэрээ байгуулсан төсөл арга хэмжээний тоо | 243182.6 | Манай байгууллагын төсөвт зар сурталчилгааны зардал байдаггүй тус орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч ажиллаагүй. Гэхдээ багууллагатай холбоотой мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудас болон facebook хаягт, Говьсүмбэр аймаг энэ долоо хоногт мэдээллээр түгээж ажилласан. Байгууллагын цахим хуудсанд нийт 160 удаагийн мэдээллийг байршуулсан. |
| **ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **Санхүү, төсвийн зохицуулалт** | | | | | | | |
| **3.1. Санхүү, эдийн засгийн нээлттэй, ил тод байдлыг хангах бодлого хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 3.1.2. Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай болгон, төсвийн урсгал болон гадаадын зээл тусламж, | 3 | Төрийн албаны цалингийн нэгдсэн системд төрийн байгууллагуудыг хамруулж гүйлгээг шуурхай гүйцэтгэх | БТ | - | Цалингийн нэгдсэн системд хамрагдсан эсэх | 243182,6 | Төрийн албаны цалингийн нэгдсэн системд бэрэн хамрагдаж гүйлгээг цахимаар хийж хэвшсэн.<br>Үр дүн: Цалингийн нэгдсэн системд бүрэн нэвтэрсэн.<br>**Хэрэгжилт: 100%** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөлийг бүрдүүлнэ. | 4 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны мэдээ оруулалтад тогтмол хяналт тавина. | БТ | Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо – 81<br><br>Хугацаандаа мэдээ оруулалтын хувь - 87.5<br><br>Тайлан илгээлтийн хувь - 100 | Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо – 75<br><br>Хугацаандаа мэдээ оруулалтын хувь – 94,8<br><br>Тайлан илгээлтийн хувь - 100 | 243182.6 | Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зорилгоор төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, сангууд гэсэн нийт 43 байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд сар бүр тогтмол хяналт шалгалтыг хийж ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 42 байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг нэг бүрчлэн хянан шалгалаа. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт эхний 9 сарын байдлаар 93 хувь байна. 2023 оны 1-3 дугаар улирлын шилэн дансны тайлан илгээлт 100 хувь. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл дутуу буюу зөрүүтэй илэрхийлсэн давхардсан тоогоор 87 байгууллагуудад 14.005.373,42 мянган төгрөгийн 141 зөрчлийг арилгуулахаар 87 хугацаатай албан бичиг хүргүүлэн биелэлтийг нь хангуулан ажиллалаа. Хугацаандаа мэдээ тайлангаа оруулдаггүй 2 байгууллагын албан тушаалтанд Төрийн албаны тухай хуулийн дагуу арга хэмжээ тооцуулахаар холбогдох удирдлагуудад албан бичиг хүргүүлсэн.<br><br><br>Үр дүн: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт сайжирч байна.<br>Шалгалтанд хамрагдсан байгууллагын тоо-43<br>Хугацаандаа мэдээ оруулалтын хувь-93<br>Тайлан илгээлт-100<br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| | 5 | Төсвийн зарцуулалтын үр ашиг, хяналтыг сайжруулна. | БТ | Хяналт шалгалтын тоо-23 | Хяналт шалгалтын тоо-21 | 243182.6 | Тайлант онд санхүүгийн хяналт шалгалт-17, дотоод аудит-17, шилэн дансны нийцлийн аудит-42 нийт 76 хяналт шалгалт төлөвлөснөөс төлөвлөгөөт 70, төлөвлөгөөт бусаар байгууллага, иргэнээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг үндэслэн 10 нийт 80 хяналт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Илрүүлсэн зөрчлийн дүн-1.239.246.900 төгрөг | Зөрчлийн дүн өмнөх онтой харьцуулахад 30 хувиар буурсан байна. | | шалгалт хийсэн. Төлөвлөгөөт 8 хяналт шалгалт хийгдэж байна. Шалгалтын явц 10-80 хувьтай. Шалгалтаар нийт 3.011.379,7 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 12.016,8 мянган төгрөгийг улсын орлого, 14.921,2 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар, 7100,2 мянган төгрөгийг хувь хүнд буцаан олгуулахаар нийт 34038,0 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоов. Актын барагдуулалт 43,1 хувьтай байна.<br>Үр дүн: Хяналт шалгалтын тоо өмнөх оноос 21-ээр нэмэгдсэн.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| **ДӨРӨВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | |
| **"Цахим Монгол" -төрийн шуурхай үйлчилгээ** | | | | | | | |
| **4.1. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим орчныг бүрдүүлэн, ил тод байдлыг ханган, иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | |
| 4.1.1 E-mongolia системээр төрийн үйлчилгээ авах орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөөгийн байгуудыг интернэт сүлжээнд холбоно. | 2 | Хөдөөгийн багуудад E-mongolia системээр төрийн үйлчилгээ авах талаарх сургалтуудыг зохион байгуулна. | БТ | - | Зохион байгуулсан сургалтын тоо | 243182,6 | Манай байгууллагад үндсэн чиг үүргийн хувьд E-mongolia үйлчилгээнд холбогдсон үйлчилгээ байхгүй. |
| 4.1.2 Төрийн үйлчилгээнд ХУР, ДАН системд тоон гарын үсгийг нэвтрүүлэн, аймаг сумдын ЗДТГ-уудын иргэдэд үйлчлэх үйлчилгээний нэгдсэн төвийг өргөжүүлнэ. | 3 | Төрийн үйлчилгээнд ХУР, ДАН систем, тоон гарын үсгийг нэвтрүүлнэ. | БТ | - | ХУР, ДАН систем нэвтрүүлсэн эсэх | 243182,6 | Манай байгууллагад үндсэн чиг үүргийн хувьд ХУР, ДАН системд нэвтрүүлэх үйлчилгээ байхгүй. |
| | 4 | Аймаг, сумын ЗДТГ-уудад иргэдэд үйлчлэх үйлчилгээний нэгдсэн төвийг байгуулан, операторын системээр төвийн үйлчилгээг үзүүлэх | БТ | - | Операторын системээр үзүүлсэн үйлчилгээний тоо | 243182,6 | Манай байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хамаарахгүй. |
| 4.1.3. Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэн, | 5 | Төрийн цахим мэдээллийн санг өргөтгөн төрийн байгууллагуудад дотоод удирдлагын ERP системийг нэвтрүүлнэ. | БТ | ERP систем нэвтрүүлсэн нутгийн захиргааны байгууллагын тоо -0 | ERP систем нэвтрүүлсэн нутгийн захиргааны байгууллагын тоо -10 | 243182.6 | Төрийн байгууллагын дотоод удирдлагын ERP системийг байгууллагадаа бүрэн нэвтрүүлж үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж хэвшсэн. Тайлант онд 512 баримт бичгийг цахимжуулсан. Мөн байгууллагын sankhuu_audit_gs@yahoo.com и-мэйл хаягыг бүх албан хаагчид ашигладаг. Албан хэрэг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| дотоод удирдлагын ERP системийг төрийн байгууллагуудад нэвтрүүлж, тусгай зөвшөөрөл, өргөдөл гомдол, санал хүсэлтийг цахимаар хүлээн авч, шийдвэрлэнэ. | | | | | | | хөтлөлтийг ERP систем болон албаны и-мэйл хаягаар илгээж байгаа бөгөөд ERP системд байгууллагын нийт албан хаагчдыг бүртгэн эрхүүдийг нээж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Ирсэн явсан бичгийн бүртгэлийг тогтмол хөтлөн ERP системээр 10 сарын байдлаар нийт 204 албан бичгийг солилцон үйл ажиллагаандаа ашиглаж байна. Үүнд:<br>- Ирсэн бичиг -85<br>- Явсан бичиг – 119 тус тус байна.<br>Үр дүн: Мэдээллийг түргэн шуурхай хүргэж байна.<br>**Хэрэгжилт-100 хувь** |
| | 6 | Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангахарга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. | БТ | - | Араг хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 243182,6 | Байгууллагын санхүүгийн мэдээллийг байгууллагын цахим хуудас болон санхүүгийн ил тод байдлын самбарт тогтмол байршуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна Шилэн дансны болон байгууллагын цахим хуудас, санхүүгийн ил тод байдлын самбарт нийт 175 санхүүгийн мэдээлэл байршуулсан. Үүнд:<br>-Шилэн дансны цахим хуудсанд- 139<br>-Байгууллагын цахим хуудсанд- 13 мэдээлэл<br>-Санхүүгийн мэдээллийн самбарт – 23 мэдээллийг тус тус байршуулсан. Манай байгууллагад цахимжуулсан үйлчилгээ байхгүй.<br>Үр дүн: ERP системийг бүрэн нэвтрүүлсэн.<br>**Хэрэгжилт 100 хувь.** |
| | 7 | Тусгай зөвшөөрөл, өргөдөл гомдол, санал хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэнэ. | БТ | Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь - 100 Хугацаа - 15 хоног | Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар хүлээн авах системийг хийлгэнэ. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь - 100 Хугацаа - 15 хоног | 243182.6 | 2023 оны 3 дугаар улирлын байдлаар гомдол шийдвэрлүүлэх тухай 1 хүсэлт, ээлжийн амралтын тухай 1 өргөдөл ирсэн бөгөөд гомдол шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг хуулийн дагуу буцаасан. Ээлжийн амралтын тухай 1 өргөдлийн хариуг 2023 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 169 дугаар албан бичгээр хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариуг хүргүүлсэн.<br>Үр дүн: Иргэний ээлжийн амралттай холбоотой асуудлыг бүрэн шийдвэрлэсэн.<br>**Хэрэгжилт-100 хувь** |
| **Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба** | | | | | | | |
| **4.2. Нутгийн захиргааны байгууллагуудыг чадавхжуулж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг дээшлүүлнэ.** | | | | | | | |
| 4.2.2. Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон төрийн байгууллагууда | 4 | Төрийн байгууллагуудад чанарын менежментийн тогтолцоо ISO MNS 9001:2016 стандартыг нэвтрүүлэх чиглэлээр | БТ | Зохион байгуулсан сургалтын тоо-0 | Зохион байгуулсан сургалтын тоо-1 | 243182.6 | Одоогоор сургалтанд хамрагдаагүй.<br>**Хэрэгжилт-30 хувь** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| д Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлж, төрийн захиргааны байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэн, гүйцэтгэлийн үр дүнг сайжруулна. | | сургалт, сурталчилгааг зохион байгуулна. | | | | | |
| 84.2.3. Төрийн албыг мэргэшсэн, тогтвортой үйл ажиллагаа явуулах, төрийн албаны залгамж чанарыг хангах, төрийн албан хаагчдын манлайлал, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх төрийн албанд шатлан дэвших нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 6 | Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, Төрийн албаны хуулийн хүрээнд мэргэшүүлэх сургалтуудад хамруулна. | БТ | Зохион байгуулсан сургалт, зөвлөгөөн-10<br><br>Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо-708 | Зохион байгуулсан сургалт, зөвлөгөөн-10-аас доошгүй<br><br>Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо-800-аас доошгүй | 243182.6 | Тайлант хугацаанд нийт ажлын байран дахь сургалт-6, мэргэшүүлэх сургалт-4, цахим сургалт-4, танхим-16 нийт 30 сургалтанд 100 хувь хамрагдсан. Мөн тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудас шинэчлэгдсэнтэй холбоотой 7 удаагийн сургалт зохион байгуулсан. Тус сургалтанд давхардсан тоогоор 157 хүн хамрагдсан.<br>Үр дүн: Мэдлэг мэргэшил дээшилж шинэ гарсан хууль, дүрэм, журмыг тухай бүр нь судалж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.<br>**Хэрэгжилт-100 хувь** |
| | 7 | Төрийн жинхэнэ албаны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, хуулийн хүрээнд сул орон тоог нөхнө. | БТ | - | Сул орон тоо гарсан тухай бүр сонгон шалгаруулалтыг зохион байгуулна. | 243182.6 | Тайлант онд орон тоо нэмэгдсэнтэй холбоотой төрийн жинхэнэ албаны 2 орон тоог хуулийн дагуу зарлаж нөхсөн.<br>Үр дүн: Байгууллага 100 хувь орон тоогоороо ажиллаж байна.<br>**Хэрэгжилт-100 хувь** |
| | 8 | Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийн, гүйцэтгэлийн үр дүнг сайжруулна. | БТ | - | Гүйцэтгэлийн үр дүн сайжирсан эсэх | 243182,6 | Тайлант хугацааны эхний хагас жилд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийг гаргаж хугацаанд нь хүргүүлсэн.<br>Үр дүн: Шалгалтаар иэрсэн алдаа зөрчлийг бүрэн арилгасан.<br>**Хэрэгжилт -100 хувь** |
| | 9 | Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. | БТ | Дэд хөтөлбөрийн хэрэгжилт -90 хувь, | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь -100 | 243182.6 | Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах арга хэмжээний хүрээнд төлөвлөгөө гарган дотоод сургалт 7 удаа зохион байгуулж ажилласан. Төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах хүрээнд 4 албан хаагчийг мэргэшсэн дотоод аудиторын сургалтад, 2 албан хаагчийг удирдлагын академийн ахлах, дэс түшмэлийн мэргэшүүлэх сургалтад, 2 албан хаагчийг АЗ-ын мэргэшүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтад тус тус хамруулсан. Мөн ажилчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах үүднээс тайлант онд 8209.5 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авч 2 албан хаагчид 1100,0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж, албан хаагчдын 16 хүүхдэд 800,0 мянган төгрөгийн бэлэг олгосон.<br>Үр дүн: Ажилчдын ажиллах нөхцөл сайжирсан.<br>**Хэрэгжилт-100 хувь** |
| 4.2.4. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн нийтийн хандлагыг төлөвшүүлнэ. | 10 | Авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | БТ | Иргэдэд зохион байгуулсан сургалт, сурталчилгааны тоо-2<br>Хамрагдсан иргэд, зорилтод бүлгийн тоо-338<br>Төрийн албан хаагчдад зохион байгуулсан сургалтын тоо-2<br>Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо-100 | Иргэдэд зохион байгуулсан сургалт, сурталчилгааны тоо-2<br><br>Хамрагдсан иргэд, зорилтод бүлгийн тоо-200<br><br>Төрийн албан хаагчдад зохион байгуулсан сургалтын тоо-2<br><br>Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо-250 | 243182.6 | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх төлөвлөгөөний дагуу дараахь ажлыг хийсэн. Үүнд:<br>- Бүх албан хаагчид 2022 оны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд бүрэн гаргуулж, баталгааны хуудсыг аймгийн ЗДТГ-ын ЭБАТ-аар баталгаажуулсан.<br>- АТГ-с зохион байгуулсан “Авилгын мөн чанар, шалтгаан, хор хөнөөл”-ийн талаарх сургалтад бүх албан хаагчид хамрагдсан.<br>-Хяналт шалгалт хийх бүрдээ ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргаж байгууллагын шилэн дансанд мэдээлж хэвшсэн. Тайлант хугацаанд нийт 24 удаа хувийн ашиг сонихрлын урьдчилсан мэдүүлгийг гаргасан.<br>-Авлигын эрсдэл ба авлига гарах нөхцөлийг бууруулах чиглэлээр байгууллагын нүүр номоор дамжуулан 184 удаагийн давтамжтай мэдээлэл өгсөн.<br>-“Авилга ба жендер” эссэ бичлэгийн уралдааны ЕБС-ын ахлах ангийн сурагчдын дунд зарласан.<br>-“Нэгдье” аянд байгууллага хамт олноороо нэгдсэн.<br>- АТГ-с бэлтгэсэн ТВ шторк, инфографик, видео график, нийтлэл теле зохиомж, хөдөлгөөнт зураг зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг байгууллагын цахим хуудас болон нүүр номонд хуваалцаж олонд түгээж байна.<br>Үр дүн: Авилга ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.<br>**Хэрэгжилт-100 хувь** |

Тайлан гаргасан: /Н.Алтанцэцэг/